

## ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ МОНГОЛ УЛСАД ТАТАХ БОДЛОГЫН АСУУДАЛД

Ц.Гүрбадам\* Б.Санжмятав\*\*

**М**онгол улсын Засгийн газар нь тус улсын үндсэн хууль, үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлуудад тулгуурлан гадаадын шууд хөрөнгө оруулалт, зээл тусламжийг авч улс орныхоо хөгжилд ашиглахад чухал ач холбогдол өгч байдаг бөгөөд ингэх нь гадаадын хөрөнгө оруулалтаар дамжуулан өөрийн орны гурав дахь хөршийн ашиг сонирхлыг өөрийн оронд бий болгох манай эрх ашигт бүрэн нийцэж байгаа болно. Энэ ч утгаар Монгол улсад бизнесийн харьцангуй чөлөөт горимыг мөрдүүлж, гадаадын хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх, түүнийг хөхүүлэн дэмжих, баталгаажуулах, хамгаалах бодлого баримталж байна.

### 1. Гадаадын хөрөнгө оруулалтын ач холбогдол

Гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО) нь дотоодын хуримтлал муутай, цөөн хүн амтай манайх шиг оронд хөгжлийг тэтгэх нэг үндсэн эх үүсвэр болохоос гадна гадаадын хөрөнгө оруулалтаар дамжуулан дэлхийн бодлогод нөлөө бүхий орнуудын ашиг сонирхлыг Монголд бий болгох замаар үндэсний аюулгүй байдлаа ч бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх боломжтой.

ГШХО нь өнөө үед үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхээс гадна эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, оруулсан хөрөнгийн ашгийн хэмжээг нэмэгдүүлэхэд байнга анхаарч байдаг, ГШХО-аас гадаадад төлөх өр үүсдэггүйгээрээ онцлогтой. Энэ утгаар гадаадын хөрөнгө оруулагч нь хөрөнгийн удирдлага, менежментийг хэрэгжүүлэхдээ хөгжиж буй орнуудад шинэ техник, технологийг нэвтрүүлж, түүн дээр ажиллах ажилчдыг сургаж бэлтгэхээс гадна эрчим хүч, материалын хэмнэлт гаргаж, оюуны хөдөлмөр шингэсэн өндөр үнэтэй, чанар сайтай бүтээгдэхүүн

\* МУИС-ийн ОУХС-ийн багш, доктор (Sc.D), профессор

\*\* магистр, ОУХ-ны эдийн засагч



гаргахад анхаарч ажилладаг. Ялангуяа гадаадын томоохон компаниас хөрөнгө оруулан байгуулсан үйлдвэрийн бүтээгдэхүүн, үйлчилгээ нь борлогдох баталгаатай зах зээлтэй байдгаараа онцлогтой.

Ийнхүү ГШХО нь бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, ажлын байрыг шинээр бий болгодог тул ард түмний орлогыг нэмэгдүүлж, зах зээл дээр бараа, үйлчилгээний хангамжийг сайжруулахаас гадна улсын төсөвт төлөх татварын хэмжээ өсч, нийгмийн асуудлуудыг шийдвэрлэх санхүүгийн эх булгийг бий болгодог. Даяаршлын XXI зуунд Дэлхийн банкнаас баримталж байгаа хөгжлийн бодлогын хоёр тулгуурын нэг нь хөрөнгө оруулах таатай уур амьсгалыг бий болгох, нөгөө нь хөрөнгө оруулалтын бий болгосон бололцоо, давуу талыг ашиглах боломжийг ард түмэнд олгох явдал гэж үздэг.<sup>1</sup>

Аливаа хөрөнгө оруулалтын эцсийн зорилго нь оруулсан хөрөнгийн эрхийг хадгалах, ашиг олох явдал юм. Хувийн компаниудаас оруулсан хөрөнгө оруулалтын дүнд бий болсон үйлдвэр, үйлчилгээний байгууллагууд нь дэлхийд ажиллаж байгаа нийт ажиллагсдын 90 хувийг ажлаар хангаж байна. Улс орны засгийн газрууд хувийн компанийн ашиг олох бололцоог хангаж өгөхөөс гадна тэдний үйл ажиллагааг мөн нийгэмд аль болох ашигтай байлгах чиглэл зорилготой зөв хослуулах бодлого явуулдаг. Ийнхүү Засгийн газраас хөрөнгө оруулалтын салбарт явуулах бодлого нь хөрөнгө оруулалтын уур амьсгалыг тодорхойлж байдаг. Засгийн газар дотоодын хөгжлийн бодлого, эрх зүйн орчноо бие даан бүрдүүлж, түүнийг хэрэгжүүлэх арга механизмаа ч өөрөө сонгож авдаг байх учиртай.

Компаниудын хөрөнгө оруулалтын ашиг нь юуны өмнө үйлдвэрлэл, үйлчилгээний болон бүтээгдэхүүн, үйлчилгээг түгээх зардал, татвар, улс төр, эдийн засаг, санхүүгийн эрсдэл, зах зээл дээр өрсөлдөхөд тохиолдох саад тотгор зэрэг хүчин зүйлүүдээс хамаарна. Мөн Засгийн газраас бизнесийн орчинг бүрдүүлэхийн тулд төрөөс үзүүлэх үйлчилгээ, дэд бүтцийн хөгжлийн түвшин, сайн засаглалын хэрэгжилт, хээл хахууль, хүнд суртал зэрэг нь багагүй цаг, хөрөнгө шаардах саад тотгорыг үүсгэх, эсхүл хөнгөлөлт болдог байна.

Хөрөнгө оруулахад макро-эдийн засгийн үндсэн хүчин зүйлүүд болох мөнгөний ханшны уналт бага байх, төсвийн алдагдлыг боломжийн хэмжээнд

<sup>1</sup> World Development Report 2005, p 2



барих, мөнгөний солих бодит ханшны тогтвортой байдал нь нэн чухал. Түүнээс гадна гадаадын хөрөнгө оруулагчид нь улс орны дотоодын дараах 3 хүчин зүйлийг онцлон анхаардаг байна. Үүнд:

- Бодлогын нааштай уур амьсгал (policy desirability);
- Улс төрийн хувьд хэрэгжих боломжтой байх (political feasibility);
- Захиргааны чиглэлээр холбогдох үүрэг өгөгдсөн, хэрэгжих боломжтой байх (Administrative feasibility).<sup>2</sup>

Өөрөөр хэлбэл дээр дурдсан хүчин зүйлүүдийн нааштай талууд хэдий чинээ их байна, хөрөнгө оруулах уур амьсгал төдий чинээ тааламжтай байна гэсэн үг юм.

Компанийн эрсдэл нь хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд өдөр тутам байдаг жирийн нэг зүйл боловч гагцхүү тэрхүү эрсдэл нь нийтийн жишгээс их, бага байгаагаас болж асуудал гарч болох талтай. Засгийн газар хөрөнгө оруулалтын эрсдэлийг багасгах талаар олон зүйлийг, тухайлбал эдийн засаг, санхүү, эрх зүйн тогтвортой орчинг хангах, оруулсан хөрөнгийн эрхийг баталгаажуулах, хөрөнгө оруулалтаас олсон ашгийг эх оронд нь буцааж шилжүүлэх бололцоогоор хангах, бодлогын ил тод бөгөөд тогтвортой байдлыг хангах зэрэг зүйлийг хийж чадна. Тухайн орны бодлого ил тод бөгөөд тогтвортой байх нь хөрөнгө оруулалтыг 30 хүртэл хувиар нэмэгдүүлдэг гэсэн судалгаа байдаг.

1970-аад онд дэлхийн улс орнууд гадаадын хөрөнгө оруулалтыг ерөнхийдөө сайн зүйл гэж үзэж хөхүүлэн дэмждэг байсан бол 1980-1990-ээд онд гадаадын хөрөнгө оруулалтыг ашиглан хөгжлийнхөө зорилтыг хэрэгжүүлэхдээ тодорхой салбаруудад түүнийг хөхүүлэн дэмжихийн зэрэгцээ, тодорхой салбаруудад хязгаарлах болсон байна. Сүүлийн 20 жилийн турш улс орнууд хөрөнгө оруулалтынхаа дэглэмийг улам бүр либералчилж, гадаадын хөрөнгө оруулалтад нээлттэй салбарынхаа тоог аажмаар нэмэгдүүлж иржээ. 1991-2003 онд гадаадын хөрөнгө оруулалтын тухай 244 хууль шинээр батлагдсан буюу шинэчлэгдсний 96 хувь нь хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин, нөхцлийг илүү

<sup>2</sup> World Development Report 2005, p 68



тааламжтай болгожээ.<sup>3</sup> Хөрөнгө оруулалтын салбарт авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд ерөнхийдөө тааламжтай болж байгаа боловч бас түүнд эергээр буюу сөргөөр нөлөөлдөг хүчин зүйлүүд ч бас байдаг.

Засгийн газраас хөрөнгө оруулалтын талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ нь өмчийг эзэмших, захиран зарцуулахаас эхлээд үйлдвэрлэл явуулах, технологи шилжүүлэх, бүтээгдэхүүнийг борлуулах зэрэг маш өргөн салбарыг хамарна. Гадаадын хөрөнгө оруулалтад хамаарах тусгай арга хэмжээнүүд нь эхний шат буюу бүртгүүлэх, зөвшөөрөл авах шатанд хамаарах боловч нэгэнт хөрөнгө оруулсны дараа үндсэнд нь дотоодын буюу гадаадын хөрөнгө оруулалт гэж ялгаварладаггүй байна. Энэ нь ДХБ-ын үйл ажиллагааны нэг үндсэн зарчим болох үндэсний нэн тааламжтай байх нөхцлийн дагуу үйлдвэр, аж ахуйн газруудыг хөрөнгө оруулалтын эх булгаас нь шалтгаалан ялгаварлан гадуурхахгүй байх зарчимд нийцэж байгаа болно. Харин хөгжиж буй орнуудад гадаадын хөрөнгө оруулагчдыг тодорхой салбарт, зөвшөөрөгдсөн хэмжээнд хөхүүлэн дэмжих үүднээс нэлээд олон төрлийн татварын хөнгөлөлт үзүүлэх, татаас өгөх, тээврийн хөнгөлөлттэй тариф тогтоох зэргээр урамшуулдаг байна.

Өнөөдрийн байдлаар хөрөнгө оруулалтын салбарын эрх зүйн орчинг дэлхийн хэмжээнд зохицуулсан гэрээ, хэлэлцээр байхгүй байна. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын хүрээнд олон улсын хөрөнгө оруулалтын асуудлаар олон талт хэлэлцээр байгуулах талаар нэлээд ажиллаж, тохиролцоонд хүрэхэд ойрхон байсан боловч тохиролцоогоо баталгаажуулж чадаагүй. Харин ДХБ-ын хүрээнд хөрөнгө оруулалттай холбоотой зарим асуудлыг зохицуулах анхны оролдлого хийгдсэн бөгөөд хөрөнгө оруулалтын олон талт хэлэлцээр байгуулах зорилготой ажиллаж байна. Худалдаатай холбоотой хөрөнгө оруулалтын арга хэмжээний талаарх хэлэлцээрт гишүүн орнууд харилцан үндэстний нэн тааламжтай байх зарчмыг хэрэглэх буюу ялгаварлан гадуурхахгүй байхаар зарчмын хувьд зохицуулсан бол Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр (ГАТТ)-ийн III зүйлийн 4-д үндэсний дэглэмийг хэрэглэх тухай, XI зүйлд тооны хязгаарлалтыг хэрэглэхгүй байх үүрэг хүлээсэн юм.

<sup>3</sup> UNCTAD, 2004 b, p8



## II. Монгол улсын гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин

Монгол улсын Засгийн газар нь гадаадын шууд хөрөнгө оруулалтын гадаад болон дотоодын эрх зүйн таатай орчинг бүрдүүлэхийн тулд дотооддоо хууль тогтоомжоо сайжруулан тогтвортой байлгах, гадаадын хөрөнгө оруулагчдад зарим хөнгөлөлт урамшуулал олгох, мөн олон улсын хэмжээнд хөрөнгө оруулалтын асуудлыг зохицуулдаг олон талт гэрээ, конвенцид нэгдэн орох, хоёр талын шугамаар холбогдох хэлэлцээрийг байгуулах чиглэлээр дэс дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Монгол улсын Гадаадын хөрөнгө оруулалт (ГХО)-ын тухай хууль 1991 онд анх батлагдаж, түүнд 1993, 1998, 2002 онуудад нэмэлт өөрчлөлт оруулан, гадаадын хөрөнгө оруулалтын илүү таатай орчин бүрдүүлэх талаар алхам хийжээ. Мөн түүнээс гадна гадаадын хөрөнгө оруулах таатай орчинг бүрдүүлэхийн тулд уул уурхай, ашигт малтмалын хууль зэрэг зарим тусгай хуулийг баталснаас гадна Татварын хууль, аж ахуйн нэгжийн тухай зэрэг багц хуулинд өөрчлөлт оруулсан болно. Ялангуяа Монгол Улс 1997 онд ДХБ-д элсэхийн өмнө буюу элссэний дараа олон талт хэлэлцээрээр авсан үүргийнхээ дагуу дотоодын хууль тогтоомжуудад нэлээд өөрчлөлт оруулсан нь эдийн засгийг зах зээлийн харилцааны нийтийн жишигт хүргэж, ГШХО-ыг татах орчинг нааштайгаар өөрчилж чадсан гэж үздэг байна. Энэ үндсэн дээр ГШХО ч Монголд нэмэгдсэн.

Монгол улс ГШХО-д хэмжээ болон оруулах хөрөнгө оруулалтын чиглэлээр ямар нэгэн хязгаарлалт үндсэндээ тавьдаггүй бөгөөд зэвсэг үйлдвэрлэхээс бусад салбарт хөрөнгө оруулахыг зөвшөөрдөг болно.

Монголд гадаадын шууд хөрөнгө оруулалтыг дараах хэлбэрээр оруулж болох юм. Үүнд:

- Гадаадын хөрөнгө оруулалттай компани, гадаадын компанийн орон нутгийн салбарыг байгуулах;
- Орон нутгийн бизнесийн хөрөнгө оруулагчидтай хамтран бизнесийн нэгж байгуулах;
- Монголын компанийн үнэт цаас, хувьцааны хэсгийг худалдаж авах замаар хөрөнгө оруулах;



- Монголын хуулийн дагуу бизнесийн болон байгалийн баялаг олборлох гэрээ хэлцлийн эрх худалдан авах;
- Маркетинг буюу менежмент хийх гэрээ хэлцэл байгуулах замаар хөрөнгө оруулах;
- Санхүүгийн лизинг буюу франчиз ажиллагаа явуулах.

Гадаадын хөрөнгө оруулалттай нэгжийг ҮХЯ-ны Гадаадын Хөрөнгө Оруулалт, Гадаад Худалдааны Агентлагт өргөдлөө өгснөөс хойш 3 хоногийн дотор бүртгэж, гэрчилгээ олгосноор үйл ажиллагаагаа явуулах эрхтэй болно. Монголд гадаадын хөрөнгө оруулагчид нь үндэсний нөхцлөөр буюу дотоодын хөрөнгө оруулагчдаас дутуугүй нөхцлөөр хангагдана. Дотоодын буюу гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд нь тайлан, бүртгэлийн хувьд олон улсын стандартыг хэрэглэж, тайлан, тэнцлээ олон улсын аудитын компаниар баталгаажуулж болно.

Монголд гадаадын иргэн буюу гадаадын компани газар эзэмших эрхгүй боловч 60 хүртэл жилээр түүнийг түрээслэн ашиглах, дотоод гадаадын зах зээлээс нэмэлт хөрөнгө мөнгө зээлээр авах боломжтой. Харин Засгийн газар гадаадаас авах зээлд баталгаа гаргаж өгөхгүй.

Дараах салбарт бизнесийн үйл ажиллагаа явуулахдаа тусгайлан зөвшөөрөл авна. Үүнд:

| Зөвшөөрөл авах бизнесийн ажиллагаа                                                    | Зөвшөөрөл өгөх байгууллага |
|---------------------------------------------------------------------------------------|----------------------------|
| Гаалийн жуучлах үйл ажиллагаа                                                         | Гаалийн ерөнхий газар      |
| Гаалийн баталгаат агуулах                                                             | Гаалийн ерөнхий газар      |
| Аюулгүй байдал, хамгаалалт                                                            | Аюулгүй байдлын хороо      |
| Худалдааны банк                                                                       | Монгол банк                |
| Банк бус санхүүгийн байгууллага                                                       | Монгол Банк                |
| Аюултай, түүний дотор эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд хортой хог хаягдал боловсруулах | БОЯ                        |
| Хортой химийн элементүүдийг импортлох, хэрэглэх, устгах ажиллагаа                     | БОЯ                        |
| Кадастрын зураг хийх                                                                  | БОЯ                        |
| Байгаль орчны дэлгэрэнгүй үнэлгээ хийх                                                | БОЯ                        |
| Их, дээд сургууль, коллеж байгуулах                                                   | БШУСЯ                      |
| Төмөр зам барих                                                                       | Засгийн газар              |
| Цахилгаан станц, эрчим хүч дамжуулах шугам барих                                      | ДБЯ                        |
| Зам барих буюу түүнийг арчлах                                                         | Авто замын газар           |
| Зочид буудал барих                                                                    | Аялал, жуулчлалын газар    |
| Геологийн эрэл хайгуулын ажил хийх                                                    | АМХЭГ                      |
| Уул уурхай                                                                            | АМХЭГ                      |
| Нефтийн үйлдвэрлэлтэй холбоотой ажиллагаа                                             | АМХЭГ                      |
| Эмийн үйлдвэрлэлийн зориулалттай ургамал тариалах                                     | ЭМЯ                        |
| Нийтийн үйлчилгээ                                                                     | Хотын захиргаа             |



Монгол улсын нутаг дэвсгэрт ГШХО-ыг нийгэмчлэх, хууль бусаар хураан авахыг хориглодог, ГШХО-уулагчдад оруулсан хөрөнгөө эзэмших, захиран зарцуулахад Монголын хөрөнгө оруулагчдаас дутуугүй нөхцөл боломж олгох болсон. Тухайлбал 2 сая ам. доллараас илүү хэмжээний хөрөнгө оруулсан гадаадын компани, иргэн Засгийн газартай Тогтвортой байдлын гэрээ байгуулах, Монгол улсад аж ахуйн нэгж бүртгүүлэхгүйгээр хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэх эрхтэй. Мөн гадаадын хуулийн этгээд Төлөөлөгчийн газраа байгуулах эрхээр хангагдсан.

Монгол улсад хөрөнгөө оруулсан гадаадын иргэн буюу компани олсон ашиг орлого, төлбөрийг ямар нэгэн хязгаарлалтгүйгээр эх орондоо буцааж шилжүүлэх эрхтэй боловч энэ тохиолдолд 20 хувийн татвар төлөх учиртай.

Монгол улс 1979 онд Дэлхийн оюуны өмчийн байгууллагад гишүүнээр элсэж, оюуны өмчийн салбарт байгуулагдсан олон улсын 7 конвенцид нэгдэн орсон ба ДХБ-д элсэхдээ оюуны өмчийн асуудлаарх олон талт хэлэлцээрийг нөхцөлгүйгээр хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн явдал гадаадын хөрөнгө оруулагчдын оюуны өмч баталгаажсаныг харуулж байна. Манай улсаас 1985 онд нэгдэн орсон “Аж үйлдвэрийн өмчийн эрхийг хамгаалах тухай (Парисын 1883 оны) конвенци”, “Барааны тэмдгийн олон улсын бүртгэлийн тухай (Мадридын 1891 оны) хэлэлцээр, 1991 онд нэгдэн орсон “Патентын хамтын ажиллагааны тухай 1970 оны Гэрээ” зэргийг дурдаж болно.

Монгол улсын Засгийн газар одоогийн мөрдөж байгаа хууль тогтоомжоор ГШХО-чдад дараах үндсэн хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлдэг. Үүнд:

1. Дулааны цахилгаан станц (ДЦС), цахилгаан, дулаан дамжуулах, шугам сүлжээ, авто зам, төмөр зам, агаарын тээврийн болон инженерийн барилга байгууламж, харилцаа холбооны үндсэн сүлжээний салбарт оруулсан татвараас 10 жилийн хугацаагаар, дараагийн 5 жилд 50 хувиар тус тус чөлөөлнө.
2. Газрын тос, хатуу түлш олборлох, боловсруулах, металлург, хими, төмөрлөг, машины үйлдвэрлэл, электроникийн салбарт татварыг 5 жилийн хугацаагаар, дараагийн 5 жилд 50 хувиар тус тус чөлөөлнө.



3. ГШХО-тай аж ахуйн нэгж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ 50-иас дээш хувийг экспортолж байвал тухайн аж ахуйн нэгжийг орлогын албан татвараас 3 жилийн хугацаагаар, дараагийн 3 жилд 50 хувиар тус тус чөлөөлнө.
4. Гадаадын хөрөнгө оруулагч нь урьд нь оруулсан хөрөнгөөсөө олсон ашиг, орлогоо тухайн байгууламждаа дахин хөрөнгө оруулбал төлөх татварын дахин оруулсан хөрөнгийн татварт ногдох хэсгийг хасч тооцно. Мөн Засгийн газартай бүтээгдэхүүн хуваах гэрээтэй ажиллаж байгаа гадаадын компанийн орлогын татвараас чөлөөлнө.
5. Засгийн газраас баталсан жагсаалтад орсон алслагдсан хөдөө орон нутагт үйлдвэрлэл, үйлчилгээ шинээр эрхэлсэн компанийг татвар төлөхөөс чөлөөлнө.
6. Аж үйлдвэр, технологийн паркад оруулсан хөрөнгө оруулалтаас олсон орлогоос төлөх татварыг чөлөөлнө.
7. Гадаадын хөрөнгө оруулагч Монголд шаардлагатай мэргэжсэн боловсон хүчин байхгүй бол гаднаас богино болон урт хугацаагаар авч ажиллуулах зөвшөөрлийг НХХЯ-наас авах боломжтой. Гадаадын хөрөнгө оруулалттай компани нь өндөр мэргэжлийн удирдах ажилтнуудаа гаднаас авчирч ажиллуулах зөвшөөрөл авахад ямар ч бэрхшээл байхгүй.

Засгийн газар 2001 онд хөрөнгө оруулах ач холбогдол бүхий тэргүүлэх салбарын жагсаалтыг баталсан. Тухайлбал үр тариа, эрчимжсэн МАА, нүүрс газрын тос, ашигт малтмалын олборлолт, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нэхмэл, үслэг эдлэл, арьс шир боловсруулалт, мод, модон эдлэл, төмөрлөг, химийн үйлдвэрлэл, хоёрдахь түүхий эдийн боловсруулалт, дэд бүтцийн зарим салбар, аялал жуулчлал зэрэг салбарт хамрагдах ГШХО-тай аж ахуйн нэгжийн дүрмийн санд гадаадаас орж ирж буй технологийн зориулалттай тоног төхөөрөмж нь НӨТ, гаалийн татвараас чөлөөлөгдөнө. НӨТ-ийн албан татварын хуульд орсон өөрчлөлтөөр алтны экспортын 10 хувийн татварыг ч хүчингүй болгосон.

Монгол улс хоёр талын шугамаар 34 оронтой хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээр, 31 оронтой давхар татвараас харилцан чөлөөлөх тухай хэлэлцээр байгуулан ажиллаж байна. Мөн



Монгол улс 1965 оны Вашингтоны “Улс болон гадаад улсын иргэний хоорондын хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх тухай конвенци”-д, 1985 оны Сөүлийн “Хөрөнгө оруулалтын даатгалын олон талт агентлаг байгуулах тухай” конвенцид тус тус нэгдсэн тул гадаадын хөрөнгө оруулагчид нь Дэлхийн Банкны хөрөнгө оруулалтын олон талт даатгалын агентлагийн (MIGA) эрсдэлийн даатгалд хамрагдах, хөрөнгө оруулалттай холбоотой маргаанаа “Улс болон гадаад улсын иргэний хоорондын хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх тухай конвенци”-ийн хүрээнд байгуулагдсан Хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх олон улсын төвд хандан шийдвэрлүүлэх бололцоотой болсон.

1985 оны Сөүлийн Конвенцид Хөрөнгө оруулалтыг баталгаажуулах олон талт агентлагийн зорилтыг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

а) аль нэг гишүүн оронд нөгөө гишүүн орноос орж байгаа хөрөнгө оруулалтыг арилжааны бус эрсдэлээс хамгаалж, баталгаа гаргах, түүний дотор хамтран болон давхар хийсэн даатгал гаргуулах;

б) хөгжиж буй гишүүн орнуудад болон тэдгээрийн хооронд хийгдэх хөрөнгө оруулалтын урсгалыг хөхүүлэн дэмжихэд чиглэсэн тохиромжтой нэмэлт үйл ажиллагаа явуулах;

в) өөрийн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай, эсхүл хүсүүштэй бусад тохиолдлын чанартай арга хэмжээ авах эрхийг эдлэх.

Агентлагийн баталгаанд дараах нөхцлийг хамруулж байна. Үүнд:

- валютыг хөрвүүлэхэд саад учрах;
- хөрөнгийг нь хурааж авах болон түүнтэй адилтгах арга хэмжээ;
- гэрээг зөрчих;
- дайн болон нийтийн эмх замбараагүй байдал үүсэх.

Агентлаг нь зөвхөн хөгжиж буй орны нутаг дэвсгэрт хийгдэх хөрөнгө оруулалтад баталгаа гаргах ба баталгаа гаргахын өмнө түүнийг хүлээн авагч орны засгийн газарт албан ёсоор мэдээлж, зөвшөөрүүлснийхээ дараа албан ёсоор амлалт авдаг журамтай. Гэхдээ агентлаг хөрөнгө оруулалтад баталгаа гаргахдаа юуны өмнө дараах үндсэн чиглэлээр судалгаа явуулж, дүгнэлт гаргадаг байна. Үүнд:

- тухайн хөрөнгө оруулалтын өгөөж болон хүлээн авагч орны хөгжилд оруулах хувь нэмэр;



- тухайн хөрөнгө оруулалт нь хүлээн авагч орны хууль, журамд нийцэж байгаа, эсэх;
- хүлээн авагч орны тунхаглан зарласан хөгжлийн тэргүүлэх чиглэлд тухайн хөрөнгө оруулалт нийцэж байгаа, эсэх;
- хүлээн авагч улс дахь хөрөнгө оруулалтын орчин, түүний дотор хөрөнгө оруулалтын шударга, эрх тэгшээр хандах хандлага, эрх зүйн хамгаалалт байгаа, эсэх.

Агентлаг өөрийн хийсэн судалгаанд үндэслэн оруулж байгаа хөрөнгийн болзошгүй алдагдлыг (бүгдийг нь заавал хариуцах албагүй) буюу хэсэгчлэн баталгаа гаргаж болно. Агентлаг нь оруулж байгаа хөрөнгөд баталгаа гаргахаас гадна хөгжиж буй орнуудад хийх гадаадын хөрөнгө оруулалтын орчинг сайжруулах зорилгоор судалгаа шинжилгээ хийж, хөрөнгө оруулалтын урсгалыг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэх, тэдгээр орон дахь хөрөнгө оруулалтын боломжуудын тухай мэдээлэл түгээж байх, хөрөнгө оруулагчид болон хүлээн авагч улсуудын хооронд үүссэн маргааныг эв зүйгээр зохицуулахыг дэмжих, хөрөнгө оруулалтыг дэмжиж хамгаалах талаар гишүүдийн дунд хэлэлцээр байгуулахыг дэмжин урамшуулж байх үүрэгтэй болно.<sup>3</sup>

Хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх олон улсын төв нь биеэ даасан, тусгаар институт болохынхоо хувьд хөрөнгө оруулагч, түүнийг хүлээн авагч улсын ашиг сонирхлын тэнцвэрийг хангаж ажилладгаараа онцлогтой, түүгээрээ нэр хүндтэй байдаг байна. Төв нь Сэргээн босголт, хөгжлийн олон улсын банкны төв байранд байрладаг. Монгол Улс 1996.05.28-нд нэгдэн орсон.

Хөрөнгө оруулснаас үүдсэн маргаанд оролцогч талууд харилцан зөвшөөрч, асуудлыг бичгээр Төвд тавьсан тохиолдолд маргааныг шийдвэрлэх үйл явц эхэлдэг байна. Маргаан шийдвэрлэх үйл ажиллагаа нь арбитрын шүүх байх тул талууд харилцан тохиролцон арбитрын шүүхийг байгуулна. Ингэхдээ тодорхой шалгуураар шалгагдаж (улс бүрээс 4 хүртэл хүнийг санал болгодог) төвийн жуучлагчдын болон арбитрчдын жагсаалтад орсон хүмүүсээс өөрийн арбитрчдыг сонгон томилдог журамтай. Маргааныг шийдвэрлэх үйл ажиллагаа арбитрын шүүхийн нийтийн жишгээр явагдах ба түүнээс гаргасан шийдвэр нь заавал биелүүлэх үүрэгтэй, гишүүн орны засгийн газар арбитрын шүүхийн шийдвэрийг

<sup>3</sup> Төрийн мэдээлэл, тусгай дугаар, боть 2, Монгол Улсын олон улсын гэрээ, УБ хот, 2005 он



өөрийн нутагт шүүхийн эцсийн шийдвэрийн нэгэн адил хэрэгжүүлэх үүрэгтэй байна.

Олон улсын практикт бизнесийн аливаа маргааныг боломжтой нөхцөлд тухайн орны арбитрын шүүхээр шийдвэрлүүлэхийг хичээдэг болно. Энэ нь арбитрын шүүх асуудлыг шуурхай шийдвэрлэх, нууцлалыг сайн хадгалах боломжтой байдагтай холбоотой. Мөн аливаа орны шүүхийн шийдвэр нь тухайн орондоо хэрэгжих эрх зүйн үндэстэй бол, арбитрын шийдвэр нь гадаад оронд ч хэрэгжих давуу бололцоотой байдгаараа зохимжтой байна. Конвенцийн 3 дугаар зүйлд зааснаар арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэхэд дотоодын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэхээс илт давуу хүнд нөхцөл буюу өндөр хураамж, татварыг хэрэглэж болохгүй байна. Маргаанд ялагч болох тал арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрүүлж, биелүүлэхийн тулд тухайн орны эрх бүхий байгууллагад зохих журмын дагуу баталгаажуулсан арбитрын шийдвэрийн эх хувь буюу түүнтэй адилтгах хуулбарыг, шийдвэрийг гүйцэтгүүлэх талаарх хүсэлтийнхээ хамт өгөх ёстой байдаг. Эрх бүхий байгууллага нь арбитрын шүүхийн шийдвэрийг зөвхөн хуулинд заасан талууд арбитрын асуудлаар хэрэглэх хуулиар эрх зүйн чадамжгүй байсан, эсхүл талууд арбитрын шийдвэр гаргасан улсын хууль тогтоомжийн дагуу үндсэн хэлэлцээр хүчингүй болсон байсан зэрэг цөөн үндэслэлээр хүлээн авахаас татгалзах эрхтэйг конвенцийн 5 дугаар зүйлд тодорхойлж өгчээ. Ийнхүү гадаадын арбитрын шийдвэр нь нөгөө оронд өөрийн арбитрын шийдвэрийн адилаар хэрэгжих бүрэн бололцоотой байна.

Монголд гадаадаас хөрөнгө оруулагчид нь бизнесийн үйл ажиллагааны явцад гарсан аливаа маргааныг Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын дэргэдэх үндэсний Арбитрт хандаж мөн шийдвэрлүүлэх боломжтой. Монгол улс “Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай конвенци”-ийн оролцогч тал болсон тул манай арбитрын шийдвэр нь конвенцийн оролцогч талууд болох дэлхийн 130 гаруй оронд хэрэгжих бололцоогоор хангагдсан.

### **III. Монголд хүлээн авсан гадаадын хөрөнгө оруулалт**



Сүүлийн жилүүдэд Монгол улсын эдийн засаг макро түвшинд тогтворжиж, эрх зүйн орчин нь нийтийн жишгийн дагуу болж байгаагаас гадна эдийн засгийн өсөлт 2 оронтой тоонд хүрсэн нь гадаадын хөрөнгө оруулалтыг татах таатай нөхцлийг бүрдүүлж байна. 2003 онд Токиод болсон Монголд хандивлагч орнуудын уулзалтаас Монгол улсын эдийн засгийн шилжилтийн үе дуусч байгаа тухай дүгнэлт гаргасан. ЮНКТАД-ын судалгаанд Монгол Улс 1993-1995 онд ГШХО-ыг татах боломж, чадавхиараа муу (low FDI potential, low FDI performance) гэж тооцогдож байсан бол 2000-2003 онд өндөр боломжтой (high FDI potential, high FDI performance) орны жагсаалтад орсон байна.<sup>5</sup>

Монгол улс 1990-2004 оны хооронд нийт 1.129.239 мянган ам. долларын гадаадын хөрөнгө оруулалтыг хүлээж авсныг гол хөрөнгө оруулагч 20 орноор үзүүлбэл:

мянган ам. доллараар

| Орон                 | Нийт      | %    | 1990-1999 | 2000   | 2001   | 2002    | 2003    | 2004    |
|----------------------|-----------|------|-----------|--------|--------|---------|---------|---------|
| 1.БНХАУ              | 447.324   | 39.6 | 0.433     | 8.577  | 6.022  | 135.315 | 53.084  | 113.891 |
| 2.Канад              | 174.207   | 15.4 | 6.347     | 40     | 44     | 4.531   | 120.110 | 43.135  |
| 3.БНСУ               | 85.683    | 7.6  | 22.590    | 10.791 | 3.416  | 15.986  | 5.439   | 7.460   |
| 4.Япон               | 65.947    | 5.8  | 32.122    | 17.127 | 1.638  | 2.754   | 6.870   | 5.437   |
| 5.Вержини арлууд(UK) | 48.275    | 4.3  | 614       | 1.345  | 15.017 | 80      | 1.536   | 29.684  |
| 6.АНУ                | 45.139    | 4.0  | 22.790    | 1.345  | 15.017 | 80      | 1.536   | 29.684  |
| 7.ОХУ                | 37.256    | 3.3  | 22.365    | 2.404  | 5.709  | 1.572   | 2.487   | 5.709   |
| 8.Их Британи         | 25.813    | 2.2  | 11.075    | 6.095  | 2.051  | 1.773   | 374     | 4.444   |
| 9.Болгар             | 30.778    | 2.7  | 23.625    | 12     | 7.133  |         | 6       | 2       |
| 10.БНХАУ (Гонг Конг) | 25.041    | 2.2  | 13.758    | 3.773  | 2.133  | 361     | 1.814   | 2.931   |
| 11.Багамын арлууд    | 18.936    | 1.7  | 186       |        | 14.589 | 200     |         | 2510    |
| 12.Итали             | 10.766    | 1.0  | 10.667    | 20     | 6      | 42      |         | 32      |
| 13.Португали         | 13.506    | 1.2  | 13.506    |        |        |         |         |         |
| 14. Сингапур         | 8.514     | 0.7  | 7.898     | 127    | 265    | 154     | 8       | 62      |
| 15.БНХАУ(Тайван)     | 11.156    | 1.0  | 7.852     | 858    | 1.769  | 276     | 223     | 177     |
| 16.ХБНГУ             | 10.403    | 1.0  | 2.711     | 351    | 708    | 1.209   | 2.917   | 2.506   |
| 17.Израиль           | 8.095     | 0.7  | 884       | 10     | 5      | 12      | 7       | 7.178   |
| 18.Малайз            | 4.539     | 0.4  | 399       | 571    | 10     | 979     | 2.080   | 500     |
| 19.Украин            | 6.153     | 0.5  | 223       | 3.338  | 56     | 53      | 2.427   | 57      |
| 20.Нидерланд         | 4.635     | 0.4  | 4.083     | 10     |        | 148     | 4.335   | 20      |
| Бүлгийн дүн          |           | 95.7 | 274.128   |        |        |         |         |         |
| Нийт ГШХО            | 1.129.239 |      | 298.644   | 90.348 | 125283 | 172512  | 205379  | 237072  |

Монгол улсын хүлээн авсан гадаадын хөрөнгө оруулалтын судалгаанаас үзвэл 1990 онд дөнгөж 2 орон хөрөнгө оруулж байсан бол өнөөдөр манайд дэлхийн 88 орны хөрөнгө оруулалт орж ирээд байна. Гадаадын нийт хөрөнгө оруулалтад эхний 5 орны эзлэх хувийн жин 72.7 хувь, эхний 10 орны эзлэх хувийн


<sup>5</sup> I.WIR, 2004, UN, p 17



жин 87.1 хувь, эхний 20 орны эзлэх хувийн жин 95.7 хувь тус тус болж байна. Эндээс харахад Монголд гаднаас оруулж байгаа хөрөнгийн 95 хувийг 20 орон, түүний дотор Ази, Номхон далайн орнууд оруулж байна. Үүнд БНХАУ манай хүлээн авч байгаа нийт хөрөнгө оруулалтын 39.6 хувийг дангаараа нийлүүлж байгаа бол нөгөө хөрш орон болох ОХУ дөнгөж 3.3 хувийг нийлүүлж байгаа нь тэнцвэргүй байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг цаг хугацааны хувьд авч үзвэл түүний 26.44 хувь нь 1990-1999 онд, үлдсэн 73.56 хувь нь сүүлийн 5 жилд Монголд орж ирсэн бөгөөд ерөнхийдөө жилээс жилд өсөх хандлагатай байна.

Монголд хөрөнгө оруулсан гадаадын компанийн тоо ч байнга өсч, сүүлийн 5 жилд дунджаар гадаадын 500 компани Монголд үйл ажиллагаагаа явуулахаар шинээр бүртгүүлсэн байна. Гэвч сүүлийн жилүүдэд манай улсад хөрөнгө оруулагчдын дотор компани, хуулийн этгээдийн эзлэх хувийн жин багасч, хувь хүмүүсийн эзлэх хувь өсөх хандлага ажиглагдаж байна. Эдгээр нь Монголд гадаадын хөрөнгө оруулалтын хүрээ байнга өргөжин тэлж байгааг нотлон харуулж байгаа хэрэг юм.



Монголд нийт бүртгэгдсэн компанийн 30.5 хувь нь худалдаа, нийтийн хоолны салбарт, 7.4 хувь нь барилга, барилгын материалын үйлдвэрийн салбарт, 6.1 хувь нь геологи, уул уурхайн эрэл хайгуул, олборлолтын салбарт, 5.3 хувь нь аялал жуулчлалын салбарт, 3.8 хувь нь хөнгөн үйлдвэрийн салбарт, 3.7 хувь нь



хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулахаар эрхээ авсан байна.

Гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд нь 70.000 гаруй ажлын байр бий болгоод байгаа бөгөөд гадаадын иргэд, компанийн удирдлага, нарийн мэргэжлийн ажлын байран дээр ажиллаж байна.

1990-2003 онуудад гадаадын 73 орны нийт 3000 шахам компани нэг тэрбум сая гаруй ам.долларын хөрөнгө оруулалт бүртгэгдсэн. Эдгээрийн 32 хувь нь гадаадын 100 хувийн хөрөнгө оруулалттай, 68 хувь нь хамтарсан хөрөнгө оруулалттай компани байна.

Гэвч гадаадын хөрөнгө оруулсан байдлыг салбар тус бүрээр авч үзвэл компаниудын үйл ажиллагаагаа явуулах эрх авсан байдлаас нилээд өөр дүр зураг гарна. Энэ нь худалдаа, үйлчилгээний салбарт харьцангуйгаар бага хөрөнгө зарж, эсвэл Монголын түншүүдтэйгээ хамтран үйл ажиллагаагаа эхлэх боломжтой бол, уул уурхайн салбар нь илүү хөрөнгө шаардлагатай холбоотой.

ГШХО-ын бүтцийг эдийн засгийн үндсэн салбаруудаар авч үзвэл:

| №   | Салбарын нэр                                 | Мянган ам.дол | Хувиар |
|-----|----------------------------------------------|---------------|--------|
| 1.  | Геологи, уул уурхайн эрэл хайгуул, олборлолт | 495.037       | 43.8   |
| 2.  | Худалдаа, нийтийн хоол                       | 168.064       | 14.88  |
| 3.  | Хөнгөн үйлдвэр                               | 85.006        | 7.5    |
| 4.  | Банк, санхүүгийн үйл ажиллагаа               | 67.136        | 5.9    |
| 5.  | Барилга, барилгын материалын үйлдвэрлэл      | 55.343        | 4.9    |
| 6.  | МАН-н гаралтай түүхий эд боловсруулах        | 55.548        | 4.9    |
| 7.  | Мэдээлэл, холбооны технологи                 | 19.660        | 1.7    |
| 8.  | Тээвэр                                       | 20.991        | 1.7    |
| 9.  | Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл            | 15.320        | 1.4    |
| 10. | Аялал жуулчлал                               | 13.072        | 1.2    |
| 11. | ХАА, газар тариалан, МАН                     | 9.306         | 0.8    |
| 12. | Соёл, урлаг, боловсрол, ШУ, хэвлэл           | 10.646        | 0.9    |
| 13. | Мебель, модон эдлэл                          | 5.441         | 0.48   |
| 14. | Эрчим хүч                                    | 5.294         | 0.48   |
| 15. | Эрүүл мэнд, гоо сайхны үйлчилгээ             | 4.012         | 0.35   |
| 16. | Нийтийн ахуйн үйлчилгээ                      | 2.475         | 0.22   |
| 17. | Цахилгаан хэрэгслийн үйлдвэрлэл              | 1.620         | 0.14   |
| 18. | Гэр ахуйн хэрэгслийн үйлдвэрлэл              | 1.386         | 0.12   |
| 19. | Үнэт зүйлс, бэлэг дурсгал                    | 1.374         | 0.12   |
| 20. | Бусад                                        | 94.469        | 8.36   |
| 21. | ДҮН                                          | 1.129.239     | 100    |



Ийнхүү ГШХО-ын бүтцийг авч үзвэл, Монголд хүлээн авч байгаа ГШХО-ын бараг хагас нь геологи, уул уурхайн эрэл хайгуул, олборлолтын салбарт байгаа ба түүний дараа нь худалдаа, нийтийн хоолны салбар орж байна.

Монголд хүлээн авч байгаа гадаадын шууд хөрөнгө оруулалтын хандлага нь дэлхийн хандлагатай зарим талаар нийцэхгүй байгаа тал ажиглагдаж байна. Тухайлбал ЮНКТАД-аас хийсэн судалгаагаар ГШХО-ын ихэнх нь үйлчилгээний салбарт орж байгаа бол манайд энэ салбарын хувь хэмжээ их биш байна. Үйлчилгээний салбарт оруулсан ГШХО 1990-2002 онд 4 дахин өсч, 2002 онд нийт ГШХО-ын 60 хувь болжээ. Энэ нь үйлчилгээний салбар дэлхийн эдийн засгийн хамгийн эрчимтэй хөгжиж, амьдралын түвшин, стандартыг дээшлүүлэхэд шийдвэрлэх нөлөөтэй байгаагаас гадна ДНБ-ний ихэнхийг бүтээх болсонтой холбоотой. Үйлчилгээний салбар болох санхүү, даатгал, техникийн үйлчилгээ зэрэг нь үйлдвэрлэлийг явуулах, худалдаалахад зайлшгүй оролцох болсон, мэдээлэл, холбооны тэргүүний технологи нь үйлчилгээний худалдааг хөнгөвчилж, мэдээллийн шинэ технологи нь мэдээ, мэдээллийг алсын зайд бага зардлаар, түргэн хугацаанд дамжуулах бололцоо олгосноороо үйлчилгээний салбарт хувьсгал гаргасан. Дээрх нөхцөл нь үйлчилгээний тодорхой хэсгүүдийг өөр өөр оронд бага зардлаар гүйцэтгүүлж, тэдгээрийг хэрэглэгч оронд нэгтгэх бололцоог олгох болов. Энэ утгаараа үйлчилгээний салбарын хөгжил нь өрсөлдөөнийг нэмэгдүүлж, глобалчлалыг түгээгч нэг томоохон хүчин зүйл болжээ.

Мөн уул уурхайн салбар нь урт хугацаанд экологийн олон бэрхшээлийг үүсгэдэг, хөгжлийг тэтгэх зүтгүүр болж чаддаггүй тул ГШХО-д түүний эзлэх хувийн жин жилээс жилд багасаж байна. Уул уурхай, олборлох салбар (Primary sector)-т орж байгаа хөрөнгө оруулалт 1990 онд ГШХО-ын 9 хувь байсан бол 2002 онд 6 хувь болж буурчээ.

Монгол улсын 2004-2005 онд хүлээн авсан ГШХО-ын хэмжээ нь ДНБ-ний 20 (18 хувь) шахам хувь болж дотоодын хуримтлалтай үндсэндээ тэнцэх болсон нь ГШХО манай эдийн засагт чухал нөлөөтэйг илтгэн харуулж байгаа бөгөөд цаашид ч ач холбогдол нь буурахгүй юм.

Гадаадын хөрөнгө оруулалттай компаниудаас улсын болон орон нутгийн төсөвт оруулдаг татварын хэмжээ байнга өсч байгаа боловч ГШХО нь гадаадын хөрөнгө оруулалтын тухай болон татварын зэрэг хуулийн холбогдох заалтын



дагуу татвараас чөлөөлөгдсөөр байгаатай холбоотой. ГШХО-тай компаниуд улсын төсөвт 2004 онд 60.7 тэрбум төгрөгийн орлого оруулсан нь нийт төсвийн орлогын 11.4 хувь болжээ.

Гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд 2004 онд нийт экспортын 50 орчим хувийг гаргасан, ялангуяа уул уурхайн салбарт энэ үзүүлэлт бараг 100 хувь болж байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт, ялангуяа хамтарсан үйлдвэр, компани, аж ахуйн нэгжүүдийн тоо, хэмжээг нэмэгдүүлэх нь оюуны багтаамж өндөртэй экспортлох бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулж, чанарыг нь олон улсын стандартын шаардлагын түвшинд хүргэх замаар дэлхийн зэх зээл дээр өрсөлдөх чадварыг дээшлүүлэх ач холбогдолтой. Ийм ч учраас орчин үеийн дэвшилтэт технологи, “нөү-хау” нэвтрүүлэх, менежментийн шинэхэн ололтуудыг өөртөө агуулсан гадаадын хөрөнгө оруулалтад манай тал тэргүүлэх ач холбогдол өгч, зүйл бүрээр хөхүүлэн дэмжих ёстой. Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тусгалаа олсон “...экспортын болон хүнсний нөөцийг нэмэгдүүлэх үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд хөхүүлэн дэмжих, экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хаягдалгүй технологи бүхий үйлдвэрлэл хөгжүүлэх чиг баримтлах, ... оюуны бүтээлийг баталгаажуулах, гадаадын технологийг Монголын нөхцөлд тохируулан нэвтрүүлэх эрхзүйн баталгааг бүрдүүлэх, ... үр дүнг үйлдвэрлэл, практикт нэвтрүүлэхэд амжилт гаргаж буй хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагад албан татварын хөнгөлөлт үзүүлэх, хөнгөлөлттэй зээл олгодог зарчим баримтлах” зэрэг чухал заалтуудыг хэрэгжүүлж, тэдгээрийг үр дүнтэй, бодит үйл ажиллагаа болгох нь чухал юм.

Монгол улсад хийгдэж буй гадаадын зээл, тусламж ГШХО нь манай ДНБ-ний 80 орчим хувьтай тэнцэх хэмжээнд хүрээд байгаа нь төдий л өндөр үзүүлэлт биш болов уу. Иймд гадаадын хөрөнгө оруулагчдыг өөртөө татах ажлыг төрийн бодлогын хэмжээнд далайцтай, тууштай нэгдсэн үйл ажиллагаагаар зөв зохион байгуулж чадвал цаашид ч улам өсөж нэмэгдэх бололцоотой гэж үзэж байна.

Дээрх зорилтын хэрэгжилт нь одоо Монгол улсад Ашигт малтмалын тухай болон Гадаадын хөрөнгө оруулалт, Татварын тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтөөс нэлээд хэмжээгээр хамаарах болно.



Ашигласан материал:

1. *Mongolian Industry and Trade, blue book – 2005, FDI review - 2004,*
2. *Гадаадын хөрөнгө оруулалтын тdйм 2004, дэд дэвтэр*
3. *ҮХЯ, ГХОГХА, АМХЭГ-ын вэб хуудаснуудад Гадаадын хөрөнгө оруулалтын тухай гаргасан материалууд*
4. *World Investment Report, 2004, 2005 [www.unctad.org](http://www.unctad.org)*
5. *World Trade Report, 2004, 2005 [www.wto.org](http://www.wto.org)*